

РОКХИЛЬ БА “ГАДААД МОНГОЛЫН АСУУДАЛ”

*Р.Болд**

АНУ-ын нэрд гарсан дипломат Уильям Вудвиль Ар Монголд ирсэн тухай манай судлаачид иш татдаг билээ. Дорно дахины судлалд оруулсан хувь нэмрээрээ үлэмж хүндэтгэл хүлээсэн Рокхиллийг АНУ-ын Ерөнхийлөгч Теодор Рузвельт нэгэнтээ “АНУ-ын Азийн эх газрын бодлогыг зохиогч” гэж нэрлэжээ. Тэрээр АНУ-аас Грек, Манж Чин улс, Хаант Орос, Туркт Элчин сайдаар сууж байв. Тус өгүүлэлд Элчин сайд, эрдэмтэн, монгол судлаач У.Рокхиллийн амьдрал, үйл ажиллагааны талаар өгүүлэв.

Дипломат албанд

Рокхиль 1854 онд Пенсильвани мужид төржээ. Түүний өвөг дээдэс нь Умард Америкт 200 гаруй жилийн өмнө Англиас ирж суурьшсан, худалдаачин, улс төр, цэргийн зүтгэлтэн, эмч зэрэг янз бүрийн ажил, алба хашиж байсан хүмүүс байжээ. Харин эхийн талын өвөг эцэг нь Марэланд мужийн захирагч байв. Эцэг Томас нь хуульч байгаад багад нь өвчний учир таалал төгсч эх нь амьдрахын эрхээр түүнийг 11 настайд нь Францад нүүдэллэн суурьшжээ. Үүнээс хойш Рокхиль насан эцэслээ ердөө 13 жилийг л АНУ-д өнгөрөөсөн байна. Залуу Рокхиль Францад дунд сургуульд шилдэг сурагч байв. Дараа нь Францын Сен-Сир дэх цэргийн элит сургуульд элсчээ. Тус сургуульд суралцаж байхдаа тэрээр араб хэлний эрдэмтэн, түүхч Эрнест Ренантай танилцаж түүний нөлөөгөөр дорно дахиныг сонирхох болсон байна. Тэрээр номын санд бүхэл өдрийг өнгөрөөж төвд хэл судлах болжээ. Сургуулиа 1873 онд төгсгөн Алжир дахь Францын колони орнууд дахь цэргийн анги болох гадаад легионд гурван жил алба хаажээ. Рокхиль франц хэл сайн эзэмшсэн, ер нь түүнийг франц маягийн хүмүүжилтэй гэж ярьдаг байв. Тэрээр Америкт буцан ирж Нью-Мексик мужид өөрийн эдлэн газарт хэсэг амьдрахдаа бие даан хятад, санскрит хэл судалж эхэлжээ. Дорно дахиныг судлах сонирхол, Хятадад очих мөрөөдөл нь түүнийг Азийн зүг дуудсаар байв. Рокхиль Бээжинд цэргийн атташегээр очихыг хүсэж хөөцөлдсөн боловч 1884 онд тэрээр Чин улс дахь ЭСЯ-нд хоёрдугаар нарийн бичгийн даргаар томилогдсон байна. АНУ Бээжинд ЭСЯ-аа 1860 онд нээсэн бөгөөд Манж чин улсад христийн төлөөлөгчдийг ирүүлж суурьшуулах явдал нь Америкийн дипломатуудын нэг үндсэн үүрэг байжээ. Бээжинд Рокхиль Ихасаас ирсэн төвд ламыг олж төвд хэл заалгажээ. Мөн 1886-1887 онд тэрээр Солонгост түр хугацаагаар Хэргийг түр хамаарагчаар ажилласан байна. Рокхиль угаас эрдмийн ажилд сонирхолтой, цаг зав л гарвал судалгааны ажилд зарцуулдаг байв. Мөн

* Р.Болд - Монгол Улсаас АНУ-д суугаа Элчин сайд

амралтаараа Шаньси муж орж Буддын хийдээр байнга очдог байжээ. Тэрээр Төвдөд явах саналаа Элчин сайддаа тавьдаг байсан боловч зөвшөөрсөнгүй. Мөн христийн шашны төлөөлөгчдийг олигтой дэмждэггүй гэсэн гомдол ч гарч байжээ. Улмаар Элчин сайд нь түүнийг үүрэгт ажлаа хийхгүй байна хэмээсэн тул тэрээр халагдах өргөдлөө өгчээ. АНУ-ын шинэ засаг захиргаа түүнийг 1893 онд Төрийн Департаментэд ерөнхий түшмэл, 1896 оноос Туслах нарийн бичгийн даргаар ажиллуулж байгаад 1897 онд Грект Элчин сайдаар томилжээ. Хэдийгээр Рокхиллийн сэтгэл санаа дорно дахинд төвлөрч, судалж, тэмүүлж байсан боловч тэрээр энэхүү томилгоог амьдралын эрхээр хүлээн авсан байна. 1898 онд АНУ-ын төрийн нарийн бичгийн даргаар Д.Хей томилогдов. Хей хувийн дотно харилцаатайн хувьд Рокхиллийг Грекээс дуудан ирүүлж дэргэдээ ажиллуулах болов. Рокхилль Төрийн нарийн бичгийн даргын даалгавраар Алс дорнод буюу Манж чин улсад АНУ-ын ашиг сонирхолыг хөрсжүүлэх бодлогын үндсийг боловсруулжээ.

Энэхүү бодлого нь АНУ-ын Төрийн Департаментын 1899 оны 9 дүгээр сар, 1900 оны 7 дугаар сард тус тус тараасан хоёр ноотод тусгагдсан “нээлттэй хаалганы бодлого” буюу Хятадын бүхий л нутаг дэвсгэрт улс гүрнүүд худалдааны ижил тэнцүү эрхтэй байх, улс гүрнүүд Хятадыг хуваасан нөлөөний хүрээндээ Хятадын бүрэн эрхийг хүндэтгэх, Хятадын бүрэн эрх, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хадгалах зарчмууд билээ. Энэ үеэс эхлэн эдгээр зарчим 1945 он хүртэл Алс дорнод, түүний дотор Хятадын талаар баримтлах АНУ-ын бодлогын тулгын чулуу болсон юм. Дээрх ноотын анхны төслийг Рокхилль боловсруулжээ. Тэрээр нударганчуудын бослогын үр дагаварыг арилган Манж чин улсыг “шийтгэх” олон улсын бүрэлдэхүүнд АНУ-ыг төлөөлөх төлөөлөгчөөр томилогдон 1900 онд ажилласан юм. Нударганчуудаас гадаадынханд учруулсан хохирлын төлбөрийг аль болох багаар тогтоох, бослогын улмаас Хятадын эдийн засаг бэрхшээлд орж мөнгөний ханш унаснаас бусад гүрнүүд төлбөрийн хэмжээг нэмэх санал тавьсаныг шударга биш хэмээн үзэж Рокхилль аль болох аядуу байр суурь баримталж байв. Нударганчуудын бослогын хохирол 333 сая ам.долларыг өрнөдийн гүрнүүдэд Манж чин улс төлөх болсоны 25 сая нь АНУ-д оногдож төлөх болсон. Энэхүү төлбөр нь Чин улсад хүнд дарамт болж улмаар цаашдаа задран унах нөхцлийг бүрдүүлэхэд багагүй нөлөөлсөн билээ. Рокхиллийн дотнын анд Теодор Рузвельт Ерөнхийлөгчөөр 1901 онд сонгогдсон нь АНУ-ын гадаад бодлогыг Алс дорнодод залах боломжийг олгожээ. Үнэхээр ч Рокхилль Ерөнхийлөгч, Төрийн нарийн бичгийн дарга нарын итгэлийг хүлээн 1900-1905 онд АНУ-ын алс дорнодын бодлогыг бараг ганцаараа тодорхойлон чиглүүлж байв. Энэ үед тэрээр Төрийн Департаментийн Америкийн орнуудтай харилцах асуудал эрхэлсэн

товчооны захирлаар ажиллаж байсан боловч, Ерөнхийлөгч, Төрийн нарийн бичгийн дарга нарын Алс Дорнодын асуудал хариуцсан орон тооны бус зөвлөх байлаа. Учир нь Төрийн Департаментэд Алс дорнодын асуудлыг хариуцсан нэгж энэ үед хараахан байгуулагдаагүй байв. Нударганчуудын бослогоор далимдуулан Хаант Орос Манжуурыг нэгтгэх гэж байна хэмээн Рокхиль үзэж санал тавьсан тул Оросын нөлөөг Манжуурт хязгаарлахын тулд түүний эсрэг Япон, Британийн холбоог АНУ дэмжсэн юм. Рокхиль “Хятад, Японы 1894 оны дайнаас эхлэн 1904-1905 оны Орос, Японы дайн хүртэлх хугацаанд Алс Дорнод дахь Америкийн ашиг сонирхолд хамгийн их заналхийлсэн нь Хаант Оросын тэлэлт...” гэж үзэж байжээ.¹ АНУ-ыг Манжуурт худалдаа хийлгэхийн тулд Манжуурын хотуудыг гадаадынханд нээлттэй болгохыг АНУ Хятад, Оросоос шаардаж эл асуудлаар тэдгээрийн хооронд зуучлах саналыг 1903 онд Рокхиль тавьж байв. Энэ үеэс Рокхиль Алс дорнодод Хятад, Оросын хоорондын харилцаа чухал нөлөөтэй болно, тэдгээрийг зуучлах боломжтой гүрэн нь АНУ гэсэн бодол агуулах болжээ. Рокхиллийн санаачилгаар Манж чин улс, АНУ-ын худалдааны хэлэлцээрт 1903 онд гарын үсэг зуржээ. Орос-Японы дайны үед Рокхиль илэрхийгээр Оросын эсрэг хатуу байр суурьтай байжээ.

Хэдийгээр Рокхиль Японыг Оросын эсрэг Манжуурт АНУ-ын “өмнөөс” байлдаж байна хэмээн үзэж дэмжин хариуд нь Японоор АНУ-ын нээлттэй хаалганы бодлогыг Манжуурт дэмжүүлж Хятадыг бэхжүүлэх байр суурьтай байсан боловч энэ талаар болсон билээ. Солонгосыг Японд “өгөхийг” Рокхиль л Рузвельтээр дэмжүүлж, Рокхиллийн саналаар л АНУ Солонгосоос ЭСЯ-аа татан гаргажээ. Гэтэл Японы тал АНУ-ын сонирхлыг үл тоомсорлон Манжуурт худалдааны ноёрхолоо дангаараа тогтоов. Хятадыг дээрэлхэх Оросын бодлогыг АНУ эсэргүүцэж байсан ч Хятад, Америкийн харилцаа тийм ч таатай байсангүй. Хятадын цагаачдын тоог хязгаарлах хэд хэдэн хууль АНУ-ын Конгресс гаргасны нэг нь зөвхөн оршин суух зөвшөөрөл авсан хятад цагаачдыг л оруулах 1892 оны шийдвэр байв. Үүний улмаас 1905 онд АНУ-д ирсэн хятад цагаачдын дөрөвний нэг нь буцааж байсан юм. Ялангуяа Калифорнид хятадын цагаачдыг гадуурхах, эсэргүүцэх хөдөлгөөн хүчтэй байв. Иймд Америкийн барааг худалдан авахаас татгалзах хөдөлгөөн Хятадад ялангуяа орон нутагт 1904-1906 онуудад хүчтэй өрнөж Америкийн пүүсүүд үлэмж алдагдал хүлээх болжээ. Ийм нөхцөлд Рокхиль Манж чин улсад суух АНУ-ын Элчин сайдаар 1905 онд томилогдов. Рокхиль нь Ерөнхийлөгч Т.Рузвельтээр, Төрийн нарийн бичгийн дарга Д.Хей нартай найз нөхдийн сайн харилцаатай байсан нь түүний амжилтад бас нөлөөлсөн юм. Манж чин улс нударганчуудын бослогын улмаас учруулсан хохиролын төлбөр, хүүгийн хамт 50 сая долларыг 1939 он хүртэл АНУ-

д төлж барагдуулах ёстой байв. Рокхилль үлдсэн төлбөрийг Хятадын оюутнуудыг АНУ-д сургах боловсролд зарцуулах саналыг хүчлэн тавьж Ерөнхийлөгч Рузвельтээр дэмжүүлжээ. Ингэснээр Хятадын олон мянган оюутан АНУ-д боловсрол эзэмшжээ. Энэ нь Америк, Хятадын харилцааг ойртуулсан чухал арга хэмжээ болсон. Нөгөө талаар энэ нь АНУ-д хэдтээ Тайванийг ялангуяа Чан Кайшиг дэмжих хүчтэй лобби бий болох үндсийг тавьжээ. Энэ лобби маккартизмын үед О.Латтиморыг “коммунист Хятад, Гадаад Монголыг дэмжигч, улааны тагнуул” гэсэн суртал нэвтрүүлгийг зохион байгуулж, Монгол, АНУ-ын хооронд дипломат харилцаа тогтоохын эсрэг ятгалгыг АНУ-ын Конгресст, албаны бүлгийн дунд хүчтэй хийж байв. Далай лам Рокхилльд өөрийнхөө зөвлөхөөр ажиллах хүсэлт 1905 онд тавьснаас хойш Рокхилль Далай ламын бие төлөөлөгчтэй Бээжинд байнга уулзалдах болжээ. Далай ламтай учрах нь түүний нэг мөрөөдөл байв. Далай лам Өргөөд байхдаа оросын эрдэмтнээс төвд хэл судалдаг, шарын шашныг сонирхдог өрнөдийн эрдэмтний нэрийг олж өгөхийг хүсэхэд түүнд Рокхиллийг зааж өгсөн аж. Рокхилль 1908 онд Шаньси мужид очин Далай ламтай анхлан уулзжээ. Манжуурын адил Төвдийг Хятадаас салгахыг АНУ эсэргүүцэж байгаагаа Британийн талд Рокхиллийн саналаар 1902 онд илэрхийлж байв. Рокхилль Британид Төвдтэй худалдаа хийхээс өөр муу бодолгүй гэдгийг Далай ламд хэлж, Энэтхэгтэй нягт харилцаа тогтоох хэрэгтэй гэж зөвлөжээ. Эдгээр нь Далай ламд ихэд таалагдсан аж. Далай лам Бээжинд 1908 онд ирэхдээ Рокхилльтэй уулзахыг хүсэхэд тэрээр ЭСЯ-ны бүх ажилтнаа дагуулан очиж байжээ. Далай лам Чин улсын эзэн хаантай уулзах ёслол бусад бодлогын талаар Оросын элчин сайд Коростовецтэй зөвлөлдөөд үр дүнд хүрээгүй тул Рокхилльтэй зөвлөлдөж байв. Энэ асуудлаар лам Доржиев Рокхилльтэй нэг биш удаа уулзжээ. Гэхдээ Рокхилль “Далай лам бол Чин улсын эзэн хааны харьяат гэдгээ бодох” гэхдээ хэрхэхийг өөрийн тааллаар л шийдэхээс биш тодорхой зааж зөвлөх аргагүй гэсэн хариуг өгч байжээ. Далай лам 1910 онд Энэтхэгт гарсанаас хойш ч Рокхилльтай харилцаатай хэвээр байв. Далай лам “Америкийн Элчин сайдын нэр хүнд, мэдлэг, ёс суртахуун нь диваажинтэй адил” хэмээн түүнийг сайшаасан байдаг.² Рокхилль Бээжинд Элчин сайдаар ажиллах хугацаанд таагүй зарим нөхцөл үүсч байлаа. Өмнөд Манжуур, Транс Сибирийн төмөр замыг худалдан авах санаатай байсан Америкийн төмөр замын магнат Харримантай тэрээр санал бодол зөрөлдөж байв. Манж чин улс Европын гүрнүүдтэй тэнцвэр барих үүднээс АНУ-д 1898 онд Кантон-Ханкоугийн төмөр замын шугам барих эрх өгсөн байсан боловч үүнийгээ 1908 онд хүчингүй болгосон нь түүний хувьд дипломат том цохилт байлаа. Ерөнхийлөгч Рузвельт түүнийг Христийн төлөөлөгчдийг дэмждэггүй гэсэн шүүмжлэл хүчтэй байгааг анхааруулж байв. Сүүлдээ

Ерөнхийлөгч, Төрийн нарийн бичгийн даргын зүгээс Рокхиллийг асуудлыг Америкийн биш харин Хятадын өнцгөөр харах болсон хэмээн буруутгах өнгө аяс цухалзуулан сэтгэл дундуур байх болжээ. 1909 онд АНУ-ын Ерөнхийлөгч Тафт ажлаа хүлээн авсны дараа Рокхиллийг Хаант Орост суух Элчин сайдаар томилов. Харин Рокхиль Орост очих дургүй, Хятадад үлдэх эсвэл Константинополид томилогдох хүсэлтэй байжээ. Учир нь Ерөнхийлөгч Тафтийн сонгосон Алс дорнод дахь “долларын дипломат” бодлогыг тэрээр анхнаасаа таалаагүй иймд хэрэгжүүлэхэд нь оролцох дурамжхан байжээ. Нөгөө талаар Манжуур дахь Японы худалдааны ноёрхлын эсрэг олон улсын синдикаттай хамтран АНУ-ын ашиг сонирхлыг бий болгох, урагшлуулах бодлогыг хүчтэй дэмжигч Харбин дахь Ерөнхий консул У.Стрейтэй санал зөрөлдөж байв. Учир нь Манжуурт Японыг нэвтрүүлсэн хүн нь Рокхиль хэмээн Стрейт дурамжхан байсан. “Долларын дипломат бодлого” нь Орос, Японыг Манжуурт ойртуулж нөлөөний хүрээгээ хуваасан ил, нууц хэлэлцээрүүд байгуулахад хүргэсэн билээ. Тухайлбал Манжуурт Амурын эрэг хүртэл төмөр зам барихаар тохиролцсон АНУ, Хятадын хэлэлцээрийг Орос эсэргүүцэн оронд нь Хаалган-Өргөө-Хиагт гэсэн шугамд зам барихад хөрөнгө оруулахыг санал болгосон боловч Рокхиль энэ саналыг хүлээн авах талаар хүчилсэнгүй. Америкийн дипломат уламжлалт бодлого олон улсын эрхээр хангагдсан эрхээ хамгаалах энэ хүрээнд гол төлөв арилжаа, шашны эрх ашгаа урагшлуулах үндсэн хоёр үүрэгт л төвлөрч иржээ. Гэтэл шинэ нөхцөл, шинэ үүрэг зорилгод Рокхиль дасахгүй байлаа. Манжуурт төмөр замд төвийг сахиулах АНУ-ын саналыг Хаант Оросоор Рокхиль дэмжүүлж чадаагүй тул тэрээр огцрох өргөдлөө өгчээ. Гэхдээ Ерөнхийлөгч Тафт түүнийг Туркт Элчин сайдаар томилогдох хүсэлтийг нь болгоосон байна. АНУ-ын Ерөнхийлөгчөөр Уилссон 1912 онд сонгогдов. Тогтсон журам ёсоор Америкийн Элчин сайд нар шинэ Ерөнхийлөгчид огцрох өргөдлөө гаргахын хамт уг албан тушаалдаа үлдэж ажиллах эсвэл дипломат албанд өөр улсад томилогдох хүсэлтэйгээ илэрхийлдэг байна. Гэвч шинэ Ерөнхийлөгч 1913 онд Ханс Моргентгауг Туркт Элчин сайдаар томилжээ.

Дорно дахиныг судлаач эрдэмтэн

Рокхиль төвд хэлнээс “Dhammapanda”, “Praitimoksha Sutra” судрыг франц хэлнээ орчуулж 1883 онд хэвлүүлсэн нь түүний анхны амжилт байлаа. Тэрээр АНУ-ын нэртэй дорно дахиныг судлаач У.Д.Уайтнейгээс баяр хүргэсэн захидал авч байв. Түүний зэрэгцээ Монголд ажиллаж байсан христийн шашны хүмүүс Рокхиллийг хүчин чармайлтаа зөвхөн христост зориулахыг шаардсан захидал ирүүлж байжээ. Рокхиль 1889 онд Төвд, Монгол буюу одоогийн Цайдам,

Өвөрмонголын Ордосоор аялжээ. Тэрээр 1888 оны 12 дугаар сард ганц хятад бараа бологчийн хамт аян замд гарч найман сарын турш есөн мянга гаруй км зам туулжээ. Түүний зорилго нь түүх, геологи, зан заншлын холбогдолтой мэдээлэл цуглуулах явдал байв. Рокхиль Шаньси мужид нэгэн том хөндийд буддын 65 хийд төвлөрч тэнд олон мянган монгол, төвдүүд хуран мөргөл хийж байхыг харжээ. Орон нутгийн түшмэдийн байцаалтнаас зайлсхийхийн тулд тэрээр цааш монгол лам нарын адил шар дээл өмсөн халх монголчуудын хамт хөдөлсөнөө тэмдэглэсэн байдаг. Улмаар Гүмбүмд очиж цамын ёслол үзсэн байна. Төвдийн дорнод хэсгээр явж, лам нарын дунд хэсэг амьдарчээ. Чингэхдээ түүнд анх төвд хэл зааж байсан ламтай учирч байжээ. Рокхиль аялалынхаа тэмдэглэлд үндэслэн “Ламын Орон, Хятад, Монгол, Төвдөөр зорчсон тэмдэглэл” (The Land of the Lamas, Notes of a journey through China, Mongolia and Tibet) номоо 1891 онд хэвлүүлжээ. Рокхиль Смитсониан хүрээлэнгийн тусламжтайгаар 1891 онд Төвд, одоогийн Өвөр монголоор дахин явсан байна. Түүний зорилго нь Төвдийг зүүн хойноос гаталж баруун өмнөд хэсэгт нь хүрэх улмаар Энэтхэгт очих явдал байв. Тус аялалын дунд үндэслэн Рокхиль “Төвд, Монголд 1891, 1892 онуудад зорчсон тэмдэглэл” (Diary of a Journey through Mongolia and Tibet in 1891 and 1892) номоо 1894 онд хэвлүүлэв. Гэрэл зураг, замын маршрут бүхий тус ном нь өмнөх аялалаас хуримтлуулсан туршлагадаа үндэслэн ажиглалтыг илүү өргөн хүрээтэй тусгаж, сонирхолтой олон баримтыг агуулжээ. Төвдөд аялаж байхдаа Рокхиль өрнөдийн хүмүүс очоогүй олон газраар орж судалгаа хийжээ. Тэрээр зорчсон газар орны талаар ямар нэгэн үнэлэлт, дүгнэлт хийлгүй ердөө л цуглуулсан мэдээлэл, уулзаж ярилцсан тэмдэглэл, үзэж харсан ажиглалтаа байгаагаар нь тусгажээ. Энэ байдлаараа ч эдгээр хоёр ном нь одоо ч гэсэн судлаачдад үнэтэй чухал хэрэглэгдэхүүн болсоор байна. Рокхиль Энэтхэгийн иргэн Сарат Чандрагийн Төвдөд зорчсон тэмдэглэлийг хянан тохируулж “Journey to Lhasa and Central Tibet” /Лхас болон Төв Төвдэд зорчсон тэмдэглэл/ гэсэн ном болгон 1899 онд мөн хэвлүүлжээ. Эдгээр бүтээл нь түүнийг зах хязгаар нутгийг судалсан, дорно дахины судлалыг АНУ-д хөгжүүлэхэд түлхэц өгсөн хэмээн үнэлэгдэж байв. Британийн Эзэн хааны газар зүйн нийгэмлэг Рокхильд өөрийн алтан медалийг гардуулахдаа дэлхий дээрх “Хятад, Төвдийг мэддэг гуравхан хүний нэг, төвдийн бурхны уран зохиолыг мэддэг ганцхан хүн” гэж тодорхойлжээ. Рокхиль элчин сайдаар сууж байхдаа өдрийн дийлэнхийг номын сандаа “юу хийж байгаа нь мэдэгдэхгүй” өнгөрөөдөг зожигдуу хүн байжээ. Мөн олон хүний дипломат арга хэмжээнээс зайлсхийж, цаг чөлөө л гарвал орчуулга, судалгаа хийж номноос салдаггүй байсан гэнэ. Грект ажиллаж байхдаа Гильом Рубруккийн “Дорно зүгт аялсан түүх”-ийг францаас хэлнээс орчуулсан

нь олон удаа хэвлэгджээ. Рокхиль “Америкийн түүхийн тойм” (American Historical review) сэтгүүлд “Diplomatic Missions to the Court of China. The Kowtow Question” (“Хятадын хааны ордонд зарсан элчин алба буюу сөгдөх ёсон”) өгүүлэл нийтлүүлж өрнө, дорно хоёрын дипломат ёс журам, эрх ямбын талаарх ялгааг задлан шинжилсэн нь Чин улсад томилогдож буй олон орны дипломат ажилтнуудын гарын авлага болж байжээ. 1893 онд түүний нийтлүүлсэн “Хятад дахь лалынхан ба Дунганы бослого”, “Төвдийн бурханы төрсөн түүх” өгүүллэгүүд нь олны анхаарал татаж байв. Рокхиль “Хятад, Солонгосын харилцаа: XV зуунаас 1895” (1905) жижиг товхимлын зохиогч юм. Бас түүний сонирхол нь олон улсын эрх зүй байжээ. Тэрээр Хятад, Солонгост холбогдох олон улсын гэрээ, хэлэлцээрийн хоёр ч эмтхэтгэл гаргажээ. Энэхүү практик нь олон улсын харилцаа, эрх зүйн судлалд эдүгээ ч хэрэгжиж буй чухал чиглэл болсон билээ. Түүний удирдлагад ажиллаж байсан Америкийн дипломатч А.Макмаррей “Хятадад холбогдох олон улсын гэрээ, хэлэлцээр” (1919) эмхтгэн хэвлүүлэхдээ түүний дурсгалд зориулсанаа тэргүүн нүүрэнд нь бичсэн байдаг. Рокхиль мөн XIII зуунд бичигдсэн Хятадын нэгэн нэртэй судрыг орчуулж эхэлсэн боловч дуусгаж чадаагүй байна. Рокхиллийн үзэл бодол АНУ-д гүн ухааны бүхэл бүтэн урсгал төрөхөд нөлөөлсөн гэж үзэх дүгнэх явдал ч байдаг аж. Тэрээр Америкийн газар зүй, түүх, дорно дахины сэтгүүлд цамын бүжиг ёслол, Алс дорнодын олон улсын харилцааны сэдвээр хорь гаруй томоохон өгүүлэл нийтлүүлжээ.

Монгол судлаач

Рокхиль халх монголчуудтай анх уулзсан тухайгаа “Ламын орон” номондоо “Лусар орохдоо би Оросын хилийн оролцоо байдаг Өргөөгөөс яваа олон тооны халх монголчуудтай хамтран аялав. Эзэнт улсад энэхүү омог нь хамгийн баян бөгөөд өвлийн цагт эдгээр хүмүүсийг Умард Хятад, Монгол, Төвдөд болдог цамын бүжгэн дээр харж болох бөгөөд тэд адуу, тэмээ, мөнгө, торго зэрэг үлэмж үнэтэй эдлэлийг их хэмжээгээр авчирдаг” *ᠠᠶᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰᠤᠨ*.³ Гэвч түүний 24 жилийн дараа Ар Монголд очсон анхны бөгөөд сүүлийн сэтгэгдэл нь өөр байлаа. “Европоор дайран цааш явах замдаа Рокхиль нар Гадаад Монголын нөхцөлтэй анх удаа танилцжээ. Ард түмний туйлын хоцрогдмол байдал түүнийг цочоосон боловч тэрээр энэхүү газар нутаг дахь Хятад, Оросын харилцаанд илүүтэй санаа зовсон байна...”⁴ Рокхиль Өвөр Монголд аялсан тухайгаа бичсэн “Among the Mongols of the Azure Lake” (“Цэнхэр нуурын Монголчуудын, Төвдөд зорчсон нь”) (Century XIX Jan, 1891 350-361), “A Journey in Mongolia and in Tibet” (“Монгол, Төвдөд зорчсон нь”) (The Geographical Journal III May 1894) өгүүллэгүүдийг нийтлүүлжээ. Рокхиллийн бичсэн материалуудыг үзэж байхад түүнд Ар Монголд ирж үзэх хүсэл маш их

байсан нь харагддаг. Ерөнхийлөгч Вудро Вильсон Рокхиллийн огцрох өргөдлийг ёсоор болгож түүнийг дахин албан тушаалд томилоогүй нь тэрээр Америкийн дипломат албанаас чөлөөлөгдсөн гэсэн хэрэг байлаа. Тэрээр ажлаа хүлээлгэн өгч АНУ-д буцан очиж ажил хэсэг хайсны дараа Хятадын шинэ нөхцөл байдалтай танилцахаар аялалд морджээ. Гэхдээ тэрээр АНУ-ын Засгийн газрын даалгавраар биш харин “Америкийн Азийн Нийгэмлэг”-ийн (“The American Asiatic Association”) зардал, захиалгаар явжээ. Чин улс задарч Хятадын хувьсгал гарсан, тус орны дотоод байдал төвөгтэй байсан нь Америкийн худалдаа, үйлдвэрийн бүлгийнхний сэтгэлийг зовоож байсан бөгөөд Хятадын нөхцөл байдлыг Засгийн газрын бус байр сууринаас харж дүгнэсэн ажиглалт тэдэнд хэрэгтэй байв. Иймд тус Нийгэмлэг өөрийн хуучин гишүүн Рокхиллийг илгээжээ. Рокхиль ийнхүү явахдаа Ар Монголыг зориуд зорин ирсэн байдаг. Тухайлбал Европоос Орост ирж улмаар Сибирийн төмөр замаар Манжуурыг дайран Бээжинг зорихдоо замдаа бууж цаг агаарын таатай бус байдлыг үл хайхран Хиагт уруу явжээ.

Ар Монголд ирэхийн өмнө тэрээр тэр үед Хаант Орост очсон Сайн ноён хан Намнансүрэнгэй захицлаар харилцсан байдаг. Ар Монгол дахь Хаант Оросын төлөөлөгч А.Миллер Гадаад хэргийн сайддаа 1913 оны 12 дугаар сарын 16-нд илгээсэн мэдээндээ “Константинольд сууж байсан Америкийн Элчин сайд, нэрд гарсан хятад судлаач, төвд хэлний мэргэжилтэн ноён Рокхиль 12 дугаар сарын 9-ний өдөр гэргийн хамт Өргөөд ирэв. Гучин хэмийн осгомоор хүйтэн, морь хөллөсөн хөсгөн дээр суухаас ч үл залхан Хиагтаас Өргөө хүртэлх болхидуу аялал, хүйтэн гэрт шөнө хонох зэрэг нь Рокхиллийг өөрийн биеэр Автономит Гадаад Монголын өнөөгийн байдалтай танилцах бодлыг нь зогсож чадаагүй байна” гэж бичжээ.⁵ Рокхиль гэргийн хамт Өргөөд 1913 оны 12 дугаар сарын 9-14-ний хооронд зочилжээ. Рокхиль Хаант Оросын Ерөнхий консулын газарт түр байрлаж, Ар Монголын сайд нар гэргийн хамт Рокхиль, хатагтай нартай ирж танилцах уулзалт хийсэн байна. Рокхиль ч гэргийн хамт дараа нь тэдэнтэй гэрээр тус бүртэй нь зочилж хариу уулзалт хийжээ. Харин Богд Жавзандамба хутагт өвчтэй байсан тул хүлээн авч чадаагүй аж. Рокхильд Дам лам Цэрэнчимэдийн ухаалаг байдал гүн хүндэтгэл, үлэмж сэтгэгдэл төрүүлсэн байдаг.⁶ Рокхиль Автономит Гадаад Монголын цэцэглэн хөгжих баталгаа нь Оростой ойртох явдал хэмээн хэлж байсан нь бүхий л уулзалтын хэлмэрчээр Оросын консулын ажилтан байсантай холбоотой боловч Ар Монголын хоцрогдмол байдал түүний санаснаас доогуур байсантай үүдэлтэй бололтой. Энэхүү хоцрогдмол байдлыг өмнөд хөрштэйгээ ойртоод давахгүй харин боловсрол, хөгжлийн төвшингээр түүнээс илүү болох умард хөрштэйгээ ойртож байж шийдвэрлэж болох гэсэн бодлын үүднээс бас хэлж байсан бололтой байдаг. АНУ-ын Дэд

Ерөнхийлөгч Хенри Уоллес БНМАУ-д ирснийхээ дараа мөн ийм санааг илэрхийлсэн байдаг. Хэдийгээр Миллер “Ноён Рокхиль Засгийн газрынхаа тусгай даалгавараар энэхүү урт аялалд яваа мэт сэтгэгдэл надад төрлөө. Рокхиль Юань Шикайг гучин жил мэдэх бөгөөд өөрийн дотнын найз гэж үздэг юм байна”⁷ гэж мэдээлж байсан боловч тэрээр хувиараа судлаачийн хувьд Ар Монголд иржээ. Рокхиль Орос, Хятадын хувьд хамийн сайн арга зам нь Гадаад Монголын автономийг хадгалах явдал гэсэн бодол агуулж Ар Монголоос буцсан байдаг. Ар Монголоос Бээжинд очсоны дараа түүнээс Хятадын сурвалжлагч Монголын нөхцөл байдлын талаар юу бодож байгааг нь асуухад тэрээр хариулахаас зайлсхийж харин “Өргөөд бүх зүйл тайван байна, тус хотод байгаа Хятадын гурван мянган худалдаачид өдөр тутмын ажлаа нам тайван л хийж байна. ...Хятадын банкны төлөөлөгч надад худалдаа цэцэглэн өрнөж, дэг журам давамгайлж, хүмүүс тайван байдалдаа сэтгэл хангалуун байна гэж ярьсан” гэж хэлжээ.⁸ Энэ нь Ар Монгол тусгаар тогтнолоо зарласан нь хэвийн байх ёстой үйл явдал гэсэнтэй адил мэт. Рокхиль Ар Монголд очсон тухай сэтгэгдлээ сар тутам гардаг “Америкийн Азийн нийгэмлэгийн сэтгүүл”-ийн (“The Journal of American Asiatic Association”) 1914 оны 5 дугаар сарын дугаарт “Гадаад Монголын асуудал” хэмээх өгүүлэлтийн хэлбэрээр илэрхийлжээ. Тус өгүүлэлтийг мөн Шанхайд хэвлэгддэг байсан “Алс дорнодын тойм” (Far Eastern Review) сэтгүүл 1915 онд хэвлэсэн байна. Энэ нь Америкийн Ази судлалын хэвлэлд нийтлэгдсэн Ар Монголын улс төрийн орчин үеийн түүхийн тухай бараг анхны материал юм. Манж чин улс, Хаант Орост элчин сайдаар ажиллаж байсны хувьд Рокхиль тэдгээрийн хоорондын эмзэг асуудлуудыг сайн мэддэг, тэдгээрийн хоорондын харилцааг зохицуулахад АНУ зохих нөлөө үзүүлж болохыг мэдэрсэн дипломат байжээ. Рокхиль өгүүлэлдээ Орос, Хятадын 1881 оны хэлэлцээрийг шинэчлэх Санкт-Петербургийн саналд Бээжин хариу өгөөгүй нь Хаант Оросын талд Ар Монголын 1911, 1912 оны үйл явдлыг дэмжих шалтаг болсныг дурдаад “Монгол нь Хятадтай улс төрийн харилцаагаа дуусгах хүслийг төрүүлэх тодорхой үндэслэл байсныг үгүйсгэх аргагүй” гэж бичжээ.⁹ Коростовецийн шинэ улсыг Ар Монголоор хязгаарлах, монгол ноёд тусгаар тогтносон улсаа монгол үндэстнийг бүхэлд нь оруулан тодорхойлж байсан байр суурь зөрөлдөж байсныг Рокхиль тэмдэглээд 1913 оны Хятад, Оросын Бээжингийн тунхаглалд Ар Монгол дургүйцэж байгаагаа илэн далангүй илэрхийлж байсныг дурджээ. Тэрээр “Өнгөрсөн оны 12 дугаар сард намайг Өргөөд байхад Монголын сайд нарын зарим нь яриа хэлэлцээ тэдний толгой дээгүүр явагдсан тул хэрхэвч зөвшөөрөхгүй гэдгээ илэн далангүй мэдэгдэж байлаа. ...Эднийг Хятадын мэдэлд дахин оруулах нь зөвхөн цаг хугацааны асуудал гэсэн бодлыг хятадууд агуулдаг байна. Бүрэн тусгаар тогтнол эсвэл Орост нэгтгэгдэх

гэсэн хоёрхон хувилбар байгаа боловч сүүлийн хувилбар нь Хятадын бүрэн эрхийн мэдэлд байхтай адилаар таалахгүй гэдгийг тэд хэлж байв. Тунхаглалын дагуу Хиагтад удахгүй эхлэх яриа хэлцээнд монголчууд төгс тэгш байдлаар оролцоно хэмээн оросууд амалж байгаа боловч халхууд хүчин мөхөсдөнө гэдгээ... оросууд байгаа цагт хятадуудыг Ар Монголоос ангид байлгана... гэдгээ мэддэг байна” бичжээ.¹⁰ Рокхилийн сэтгэл түгшсэн асуудал нь халхууд “...унших, бичих ойр зуурын мэдлэгээс өөр боловсрол үндсэндээ байхгүй... XIII зуунаас хойш соёл иргэншил нэвтрээгүй... худалдаа огт мэддэггүй... аливаа зүйлд сэтгэл зовдоггүй, залхуу, хамгийн итгэмтгий хүмүүс...” байсан явдал байв.¹¹ Ар Монголд татварын тогтолцоо, Үндсэн хууль болон холбогдох хууль тогтоомж байхгүйн улмаас тусгаар тогтнолын илэрхийлэл болсон байнгын төр тогтнож ажиллах үндэс сул байна гэсэн ажиглалтыг Рокхиль хийсэн байна. Улмаар татварын гол эх сурвалжууд Ар Монголд юу байж болохыг шинжилжээ. Банк, санхүүгийн тогтолцоо үүсээгүй, мөнгөн тэмдэгт эргэлтэд байдаггүй нь гаднаас санхүүгийн зээл тусламж олгох явдлыг хааж байгааг дурдаад Монголын талд засаг, төрөө бэхжүүл гэж Хаант Оросын олгосон хоёр сая рублийн тусламжийг үндсэнд нь бурхан хийлгэхэд зарцуулсаныг шүүмжлэнгүй бичжээ. Төрийн албан хаагчдыг ажиллуулах, цэргээ тэжээх, боловсролд зарцуулах улсын төсвийг бүрдүүлэх нь тусгаар тогтнолд чухал болохыг Рокхиль дурдаад ард түмэн худалдан авах чадваргүй нөхцөлд зээлийн тогтолцоо бүрдэх боломжгүй байгааг дурдаж, гадаадын менежментийн дор гаалийн алба байгуулах санаа дэвшүүлсэн байна. Өвөр Монголчууд Ар Монголоос боловсролоор харьцангуй өндөр тул тэд Ар Монголын удирдлага дор нэгдэх үндэслэл муутай гэсэн ажиглалтыг Рокхиль хийсэн байна. Оросын тал цэрэг сургах, жижиг эмнэлэг, хэвлэлийн цех, сургууль байгуулж байгаа нь дэвшилттэйг Рокхиль онцлон тэмдэглэжээ. Рокхиль Өргөөгөөс хөдлөн Сибирь, Манжуураар дайран 1914 оны 2 дугаар сард Бээжинд иржээ. Рокхилийг Манж чин улсад эзэн хааны тогтолцоог дэмждэг, Хятадад бүгд найрамдах засаглал тогтоохын ач холбогдлыг ойлгодоггүй хэмээн АНУ-ын хятадын мэрэгжилтнүүд шүүмжилж байлаа. Тэрээр Америкийн ЭСЯ, Хятадын засгийн газрын албаны олон хүмүүстэй уулзаж санал бодлоо солилцон Шанхай бусад хотоор аялжээ. Манж чин улсын төрд ажиллаж байсан Хятадын нэрд гарсан олон зүтгэлтнүүдтэй Рокхиль сайн танил байв. Тухайлбал Юань Шикайтай 1886 онд танилцсанаас хойш хувийн сайн харилцаа тогтоосон байна. Ийнхүү Ар Монголоос Хятадад очиход нь Юань Шикай хүүгийн хамт түүнийг өөрийн улс төрийн зөвлөхөөр ажиллахыг ятгаж урьсаныг тэрээр хүлээн авчээ. Гэхдээ АНУ-д байж ажиллах нөхцөлтэйгээр тохиролцжээ. Рокхиль АНУ-д буцан ирж хэсэг байсны дараа Хятад явах замдаа Хавай аралд өвчний улмаас 1914 онд нас барсан юм. “Конгрессын номын санд Хятад, Төвд, Монголын холбогдолтой

зургаан мянган ном хандивласан түүнд Америкийн иргэд зүй ёсоор талархаж байдаг” шиг Монголын иргэд ч АНУ дахь монгол судлалд оруулсан түүний хувь нэмрийг үнэлэх ёстой билээ. “...Рокхиль нь Монголын тухай аян замын уран зохиол туурвиж үлэмж хувь нэмрээ оруулсан бусад америкчуудын нэгэн адил буюу Рой Чэгмэн Андрюс, Оуэн /Латтимор нарын төвшинд олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх ёстой”¹² гэсэн доктор А.Кэмпигийн санал зүйтэйг тэмдэглэх хэрэгтэй.

У.У.Рокхиллийн бичсэн судалгааны материалын жагсаалт

Ном

1. “The Land of the Lamas”, Notes of a journey through China, Mongolia and Tibet. New York Century Co., 1891
2. “Diary of a Journey through Mongolia and Tibet in 1891 and 1892” Washington:Smithsonian Institution, 1894
3. China’s Intercourse with Korea from the XVth Century to 1895, London:Luzac& Co.,1905
4. Treaties and Conventions with or Concerning China and Korea, 1894-1904, together with various state papers and documents affecting foreign interests, Washington:Government Printing Office, 1904
5. “Treaties, conventions, agreements, ordinances, etc, relating to China and Korea’ (October, 1904-January, 1908) Supplement Washington:Government Printing Office, 1908

Өгүүлэл

1. “Among the Mongols of the Azure Lake” Century, XIX January, 1891
2. “An american in Tibet. An Account of a Journey Through an Unknown Land. Through Northern China to Koko-nor,” Century, XIX November, 1890-March, 1891
3. “A Journey in Mongolia and Tibet” The Geographical Journal vol.III, No5 May 1894
4. “Conditions in China in 1914 as viewed from Peking,” Journal of American Asiatic Association, XIV June, 1914
5. “Diplomatic Missions to the Court of China. The Kotow Question” American Historical Review, II April and July, 1897
6. “Driven Out of Tibet. An Attempt to pass from China through Tibet into India”, Century, XXV, April, 1894.
7. “Northern Tibet and the Yellow River” Century, XIX February, 1891
8. “Notes on The Relations and Trade of China with the Eastern Archipelago and the Coasts of the Indian Ocean during the Fourteenth Century” T’oung Pao, XIV, 1913

9. "Border-land of China. A Journey Through an Unknown land". Century, XIX. December, 1890
10. "The Dalai Lamas of Lhasa and Their relations with the Manchu Emperors of China, 1644-1908, T'oung Pao, XI 1910
11. "The Question of Outer Mongolia" Journal of The American Asiatic Association Vol. XIV May, No 4 1914
12. "The United States and the Future of China", The Forum, XXIX, May 1900
13. "Through Eastern Tibet and Central China" Century, XIX March, 1891

ИШЛЭЛ

1. "Open Door Diplomat" Life of W.W.Rokhill by Paul Varg Illinois Study in Social Sciences 1974 p.56
2. Мөн тэнд p.96
3. The Land of the Lamas, Notes of a journey through China, Mongolia and Tibet 1891) p. 47
4. "Open Door Diplomat" Life of W.W.Rokhill by Paul Varg Illinois Study in Social Sciences 1974 p.118
5. "Krasny Archiv" Vol. XXXVII Tsarist Russia and Mongolia in 1913-1914 p.173
6. Тухайн үед Рокхиль Төрийн Департаментэд ажиллаж байгаагүй тул Өргөөд хийсэн уулзалтынх нь талаар ямар нэгэн материал АНУ-ын албан ёсны архивт байхгүй юм. Гэхдээ Рокхиль Бээжинд очоод Өргөөд очсон тухайгаа АНУ-ын ЭСЯ-ны ажилтнуудтай ярилцсан байдаг. Харин түүний хувийн бичлэг, тэмдэглэлүүд нь ач хүүд нь уламжлан үлдсэн гэдэг бөгөөд үлэмж хэсэг нь Harvard, Yale Их Сургуульд хадгалагдаж байна.
7. Krasny Archiv Vol. XXXVII Tsarist Russia and Mongolia in 1913-1914, p. 175
8. "An Interview with Mr.Rokhill" Journal of The American Asiatic Association Vol. XIV May, No 4 1914 p.110
9. "The Question of Outer Mongolia" Journal of The American Asiatic Association Vol. XIV May, No 4 1914 p. 103
10. Мөн тэнд 104-105 тал
11. Мөн тэнд 105 тал
12. "William Woodville Rockhill's Mongolian Travel Literature of the 1890s" by Dr.Alicia campi and Dr.Denys Voaden The Image of the Mongolia in European and Asian Travel Literature Ulaanbaatar, Mongolia July 7-9, 2005